Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# “БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ” УТҮГ-ЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

Боловсрол, шинжлэх ухааны сайд /Л.Энх-Амгалан/

*(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө баталсан:* ***Төсвийн Шууд захирагч***

Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-ын
захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Энхбат/

*(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ” УТҮГ-ЫН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЬЁГ

| № | Үндсэн чиг үүрэг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэлийн хувь | Хуудасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Боловсролын салбарын мэдээллийн систем, мэдээллийн сан болон программ хангамжийн хөгжүүлэлтийн талаар | 1 | 12 | | 3-11 |
| 2. | Сургалтын цахим контент удирдлагын систем болон программ хангамжийн хөгжлийн асуудлын талаар | 1 | 3 | | 11-13 |
| 3. | Боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх талаар | 1 | 8 | | 13-18 |
| 4. | Боловсролын салбарын мэдээллийн системийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тогтвортой ажиллагааг хангах талаар | 1 | 8 | | 18-23 |
| 5. | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын талаар | 1 | 4 | | 23-26 |
| **Нийт** | | **5** | **35** | **88,3%** | |

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ” УТҮГ-ЫН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ

**2023.11.30**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *1* | *2* | | | *3* | *4* | *5* |
| **Нэг.Боловсролын салбарын мэдээллийн систем, мэдээллийн сан болон программ хангамжийн хөгжүүлэлтийн талаар** | | | | | | | |
| 1.1 | Боловсролын салбарын төсвийн шинэчлэлтэй холбоотой төлөвлөлтийн үйл ажиллагааны судалгаа хийх, системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, тогтвортой байдлыг хангах | Улсын төсөв | - Шинээр хөгжүүлсэн модулийн тоо<br>- Шинээр хөгжүүлсэн статистик маягтын тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хүлээн авсан мэргэжлийн болон техникийн боловсролын mergejil.mn -ийг tvets.edu.mn домэйн хаяг дээр тогтвортой байдлыг хангаан ажиллуулж байна. | Төсвийн төсөл дэд системд шаардлагатай сайжруулалтын ажлыг гүйцэтгэж салбарын 2024 оны төсвийн төслийг нэгтгэх системийн тогтвортой байдлыг хангасан байна | Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсрол, Боловсрол өргөө, тусгай сургуулиудын нийт 50 маягт, 51 тайлангийн шинэчлэл, бодолт, тооцооллын өөрчлөлтийг системд тусган 2024 оны төсвийн төсөөллийг улсын хэмжээнд нэгтгэж гаргалаа.<br>Уг ажлын хүрээнд:<br>- Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 15 маягтын тооцоолол, 12 тайлан<br>- Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 5 маягтын тооцоолол, 6 тайлан<br>- Төрийн өмчийн цэцэрлэгийн төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 10 маягтын тооцоолол, 7 тайлан<br>- Төрийн бус өмчийн цэцэрлэгийн төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 3 маягтын тооцоолол, 1 тайлан<br>- Насан туршийн боловсролын төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 10 маягтын тооцоолол, 9 тайлан<br>- Боловсрол өргөө дотуур байрны төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 7 маягтын тооцоолол, 4 тайлан<br>- Тусгай сургуулийн төсвийн төсөөлөл, төлөвлөлтийн 15 маягтын тооцоолол, 12 тайланг гаргасан.<br>Төсвийн төсөл-2024 ажлын хүрээнд хэрэглэгчийн гарын авлага боловсруулж, дэмжлэг үзүүлж ажилласан. Энэхүү ажлын үр дүнд цэцэрлэг, сургуулиудаас ирүүлсэн төсвийн төслийг аймаг, нийслэл, дүүрэг, улсын хэмжээнд шат шатны санхүү, хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд хянах, нэгтгэх боломжийг бүрдүүлэн ажиллав. | *100%* |
| 1.2 | Техник болон мэргэжлийн боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх, үе шаттайгаар нэвтрүүлэх | Улсын төсөв-4,0 | - Шинээр хөгжүүлсэн модулийн тоо<br>- Шинээр хөгжүүлсэн статистик маягтын тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хүлээн авсан мэргэжлийн болон техникийн боловсролын mergejil.mn -ийг | Техник болон мэргэжлийн боловсролын салбарын салбарын мэдээллийн системийн судалгааг хийж, | Техникийн болон мэргэжлийн боловсролын салбарын мэдээллийн системийн судалгааг хийж, мэргэжлийн боловсрол, сургалтын тухай шинэчлэгдсэн хууль, дүрэм, журамтай танилцан системийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, системийн цар хүрээ, функционал шаардлагыг тодорхойлж хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулсан. Ажлын даалгаварт:<br>* Ерөнхий мэдээлэл<br>* Процесс | *30%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | tvets.edu.mn домэйн хаяг дээр тогтвортой байдлыг ханган ажиллуулж байна. | суурь системийг хөгжүүлж, статистик тайланг цахим хэлбэрээр нэгтгэх боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ. | * Системийн цар хүрээ<br>* Статистик тайлангийн цар хүрээ<br>* Мэдээлэл солилцоо<br>* Систем нэвтрүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө<br>* Дата анализ зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн.<br>Цаашид суурь системийг хөгжүүлж, статистик тайланг цахим хэлбэрээр нэгтгэх боломжийг үе шаттайгаар бүрдүүлэхээр ажиллана. | |
| 1.3 | Боловсролын тэтгэлгийн бүртгэлийн системийн судалгаа, шинээр хөгжүүлэлт хийх, нэвтрүүлэх | Улсын төсөв | - Шинээр хөгжүүлсэн модулийн тоо<br>- Шинээр хөгжүүлсэн тайлангийн тоо<br>- Цахимаар зарласан тэтгэлгийн тоо<br>- Цахимаар хүлээн авсан тэтгэлэгт хамрагдах хүсэлтийн тоо | Тэтгэлгийн хүсэлт хүлээн авах scholarship.edu.mn системийн тогтвортой байдлыг ханган ажиллаж байна. | Боловсролын тэтгэлгийн бүртгэлийн системийг шинээр хөгжүүлж үе шаттайгаар нэвтрүүлнэ. | - Боловсролын зээлийн сангийн оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, гадаад тэтгэлэг, зээл, диплом олголт, мэдээллийн сан бий болгох ажлын өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийж, зээл, тэтгэлгийн систем хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсрууллаа.<br>- Боловсролын зээлийн сангаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа дээр үндэслэн зээл, тэтгэлгийн систем хөгжүүлэх санхүүгийн тооцооллыг гарган БЗС-нд хүргүүлсэн. Үүнд: нийт ажлын цар хүрээ, ажиллах хүний нөөц, санхүүгийн тооцооллыг гаргасан.<br>- https://scholarship.esis.edu.mn системээр Монгол Улс болон Олон улсын засгийн газраас зарлагдсан 14 тэтгэлгийн зар байршуулах, өргөдөл, маягтыг хүлээн авах ажилд дэмжлэг үзүүлж системийн тогтвортой байдлыг ханган Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам", "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам" -ын хүрээнд scholarship.esis.edu.mn (https://scholarship.esis.edu.mn/) мэдээллийн системээр сургалтын тэтгэлэг өргөдөл хүлээн авахад дэмжлэг үзүүлэн ажилласан. | *100%* |
| 1.4 | Боловсролын салбарын үндсэн үзүүлэлтээр удирдлагын мэдээллийн самбар боловсруулах | Улсын төсөв | - Өгөгдөл бэлдсэн индикаторын тоо<br>Ашиглалтад оруулсан самбарын тоо | БСМС, Статистикийн удирдлагын дэд модуль | БЕГ-аас тодорхойлж ирүүлсэн индикаторт шаардлагатай суурь өгөгдөл бэлтгэх ажлыг гүйцэтгэж удирдлагын мэдээллийн самбар /dashboard/ боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна | Боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын болон төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэх, боловсруулах, дата анализын шинжилгээ хийх, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд нотолгоонд суурилсан мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх БШУ-ны сайдын 2023/08/21-ны А/336 тоот тушаалын хүрээнд "Боловсролын салбарын мэдээллийн системд өгөгдлийн шинжилгээ хийх, виртуал өгөгдлийн санг үүсгэх, салбарын индикаторуудыг тодорхойлох, өгөгдлийн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах" зорилгоор БМТТ-н харъяанд салбарын өгөгдлийн удирдлагын багийг байгуулсан. Уг зорилгын хүрээнд<br>* Боловсролын салбарын өгөгдлийн сангийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, хэрэгцээг тодорхойлох, өгөгдлийн шинжилгээ хийх мэдээллийн бэлэн байдал /датасет/ болон бусад байгууллагаас авах мэдээллийн сангийн талаарх нөхцөл | *90%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлыг үнэлж эхний чухал гэж эрэмблэгдсан 3 үзүүлэлтэнд анализ хийхээр цар хүрээгээ гаргасан -100%<br>*БШУЯ-наас байгуулагдсан Өгөгдлийн Удирдлагын Ажлын хэсэг (ӨУАХ)-ээс батлуулсан Багшийн хомсдлын шинжилгээг a) багшийн хомсдолын цар хүрээг тодорхойлох, b) нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, c) багш нарын мэргэжлийн замналд ямар хандлага давамгайлж байгааг тодруулах чиглэлд дээрх шинжилгээг гүйцэтгэж, холбогдох индикаторууд, өгөгдлийн сет (dataset), өгөгдлийн зураглал (data mapping)-ын хамт боловсруулж, өгөгдлийн анализийг төслийн зөвлөхүүдтэй хамтран 2023 оны 11-р сарын 29-ний дотор эхний байдлаар боловсруулж санал авсан.<br>* Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас өгөгдөл авах мэдээлэл солилцохоор албан ёсоор хандаад хариу хүлээж байгаа.<br>* Боловсролын салбарын өгөгдлийн сангийн шинжилгээний эхний загвар платформ хөгжүүлэх замын зураглалыг гаргаж танилцуулсан.<br>*Unified Data Platform(UDP) үүсгэх асуудлаар Google Service provider компанитай хамтран ажиллах уулзалтыг зохион байгуулж, өгөгдлийн анализын дэд бүтцийг үүсгэх талаар төлөвлөн ажилласан.<br>- * Боловсролын салбарын өгөгдлийн сангийн шинжилгээний загвар платформ хөгжүүлэх, БМТТ-ийн болон бусад байгууллагын өгөгдийн сан-д холбох, тодорхойлсон өгөгдлийн зураглалын дагуу өгөгдөл солилцох сервис бичих ажлыг төслийн хамтрагч Google Service Provider-тай хамтран хэрэгжүүлэх. UDP-д цаашид анализ хийх ажлын урсгалыг Яамны холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж, анализ хийх чадавхыг бүрдүүлэхийн тулд Unified Data Platform (UDP) ашиглан өгөгдлийн шинжилгээ хийх арга зүйн зааварчилгаа боловсруулахаар төлөвлөгөө гаргасан. | |
| 1.5 | Нэгж байгууллага дээр ашиглагдаж буй систем болон бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх | Улсын төсөв | - Шинээр нэвтрүүлсэн мэдээлэл солилцооны сервисийн тоо,<br>- Мэдээлэл солилцсон байгууллагын тоо | ЗГ-ийн 2022 оны 196 дугаар тогтоолоор “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, БШУ-ны сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар БСМС- | Боловсрол, сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын болон бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох замаар нэгж байгууллагын | Боловсрол, сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системтэй мэдээлэл солилцох ажлын хүрээнд 2023 онд 20 орчим сервисийг нэмэлтээр хөгжүүлэлж, хувийн хэвшлийн компаниудад нийт 40 гаран сервисийн үйлчилгээг гарган мэдээлэл солилцох орчин нөхцлийг бүрдүүлж ажилласан. Дараах сервисүүдийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийсэн:<br>*Байгууллагын мэдээлэл /Багшийн жагсаалт, байгууллагын заах аргын нэгдэл, судлагдахууны жагсаалт, барилга байгууламжын жагсаалт, барилга байгууламжийн өрөөний жагсаалт/<br>*Багшийн мэдээлэл /Сэдвийн сангийн жагсаалт, хичээлийн сэдвийн сангийн жагсаалт, багшийн заадаг хичээлийн жагсаалт, багшийн заах аргын нэгдэл/<br>*Суралцагчийн мэдээлэл /Суралцагчийн нэмэлт мэдээлэл хадгалах, сурах бичгийн төрлийн жагсаалт/ | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ийн “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам” батлагдсан. | хүний нөөцийн ажлын ачааллыг бууруулна. | *Төсөв хөрөнгө /Төсөв орлого зарлагын маягтын мэдээлэл харах, төсөв орлого зарлагын маягын мэдээлэл хадгалах, төсөв хөрөнгийн маягтын мэдээлэл харах, төсөв хөрөнгийн маягтын мэдээлэл хадгалах/<br>Мэдээлэл солилцооны хүрээнд төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс сургалтын байгууллагын удирдлагын системийн захиалга хийн, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан 5 компанид 400-аад сургууль, 15 орчим цэцэрлэгийн боловсролын салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох эрхийг олгож, мэдээлэл солилцож байна.<br>Эрх нь олгогдож токен авсан сургуулиудын Боловсролын салбарын мэдээллийн систем (esis)-ийн мэдээлэл оруулах эрхийг систем нэвтрүүлсэн байгууллагатай тохиролцон үе шаттай хязгаарлах 2023/03/22-ны 13/1139 тоот албан бичгийн хүрээнд Багшийн систем (bagsh.esis.edu.mn) системийн багшийн цахим журналын дараах модулиудыг хааж, сургалтын байгууллага зөвхөн LMS/SMS дээр ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж ажилласан. Үүнд:<br>* Багшийн журнал /Ирц, тэмдэглэл, үнэлгээ 1, үнэлгээ2/<br>* Ангийн журнал /Өдрийн ирц, хуваарь, тэмдэглэл/<br>* Ээлжит хичээл, хичээл сонголт, сэдвийн сан<br>* Чөлөөний удирдлага | |
| 1.6 | Боловсролын салбарын төрийн албан хаагчдын мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системтэй мэдээлэл солилцох замаар “Боловсролын салбарын мэдээллийн систем”-тэй шат дараатай интеграци хийх | Улсын төсөв | - Мэдээлэл солилцсон сервисийн тоо<br>Шинээр хөгжүүлсэн модулийн тоо | ЗГ-ийн 2022 оны 196 дугаар тогтоолоор “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, БШУ-ны сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар БСМС-ийн “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам” батлагдсан. Төрийн албаны зөвлөлтэй хамтран мэдээлэл солилцох судалгааг хийсэн. | Төрийн албаны зөвлөлийн системийг веб сервисээр Боловсролын салбарын мэдээлэл системтэй холбож холбогдох мэдээллийг шат дараатай солилцдог болсон байна. Боловсролын салбарын хүний нөөцийн бүртгэлийн дэд системд шаардлагатай хөгжүүлэлтийг хийж, нэвтрүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системийн шинэ хувилбарын бүтэц, өгөгдөл мэдээллийн бизнес шинжилгээ, мэдээллийн урсгал, ямар хугацаанд, ямар давтамжтай холболт хийгдэх зэргийг тодорхойлох судалгаа шинжилгээний ажлыг хийсэн.<br>ТАЗ-аас гаргасан ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (ХНУМС)-ИЙН REST API (1.0.0) албан ёсны мэдээлэл солилцооны дараах сервисүүдийн мэдээлэл солилцооны эрхийг авч боловсролын салбарын системийн аль хэсэгт мэдээллийг шинэчлэн хэрхэн дүйцүүлэн татах харьцуулалт судалгааг хийж гүйцэтгэсэн. *Байгууллага (Объектын нэр Веб сервисийн нөөцрүү хандах, Албан байгууллага /legalEntities, Салбар нэгж /businessUnits, Дотоод нэгж /departments, Байршил /locations)<br>*Ажил (Ажлын бүлэг /jobFamilies, Ажил /jobs, Ажлын боломжит цалингийн зэрэглэл /jobs/{id}/child/validGrades, Ажлын байр /positions)<br>*Ажлын байрны боломжит цалингийн зэрэглэл/positions/{id}/child/validGrades<br>*Ажилтан (Ажилтан /employees, Ажилтны ажил эрхлэлт /employees/{id}/child/assignments)<br>*Цалин (Ажилтны нэмэгдэл цалин хөлс /employees/{id}/child/compensations, Цалингийн схем /salarySchemes<br>- Цалингийн схемийн зэрэглэл /salarySchemes/{id}/child/grades, Цалингийн зэрэглэл /salaryGrades | *70%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Цалингийн зэрэглэлийн үнэлгээ /salaryGrades/{id}/child/rateValues,<br>- Цалингийн зэрэглэлийн шатлал/salaryGrades/{id}/child/steps<br>- Цалингийн зэрэглэлийн шатлалын үнэлгээ/salaryGrades/{id}/child/steps/{childId}/child/rateValues<br>- Цалингийн үнэлгээ /salaryRates 43<br>Цалингийн үнэлгээний утга /salaryRates/{id}/child/rateValues ) | |
| 1.7 | Бага, дунд боловсролын статистикийн мэдээллийг Монгол улсын үндэсний статистикийн хорооноос шинэчлэн баталсан маягт, аргачлал, зааврын дагуу цахим хэлбэрээр нэгтгэх тайлангийн системийг шинэчлэн хөгжүүлэх | Улсын төсөв | - Шинээр хөгжүүлсэн анхан шатны маягтын тоо<br>- Шинээр хөгжүүлсэн захиргааны маягтын тоо<br>Шинээр хөгжүүлсэн албан ёсны маягтын тоо | Монгол улсын үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/137 тоот “Бага, дунд боловсролын болон техникийн мэргэжлийн боловсролын статистикийн мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг зөвшөөрч батлах, батлах тухай” тушаал батлагдсан. Бага дунд боловсролын салбарын статистик тайлан мэдээллийг цахим хэлбэрээр нэгтгэн бүрдүүлдэг. | Шинэчлэн батлагдсан бага, дунд боловсролын статистикийн анхан шатны 34, захиргааны 72, албан ёсны 20 маягт нийт 126 маягтын хөгжүүлэлтийг системд тусган тайлант үеүдэд шат дараатайгаар нэвтрүүлсэн байна | Бага, дунд боловсролын статистикийн мэдээллийг шинэчлэгдсэн маягтын дагуу улсын хэмжээнд 871 сургалтын байгууллага, 22 БШУГ, 9 БХ, 28 НТБ нийт 930 байгууллагын өвөл, хавар, намрын статистик тайланг нэгтгэн гаргалаа.<br>Шинэчлэгдсэн нийт 128 статистик тайланг шинэчлэн хөгжүүлж цахим хэлбэрээр нэгтгэх ажлын хүрээнд нийт 113 тайлангийн хөгжүүлт хийж, 89 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>*Анхан шатны – 35 тайлангаас 35 тайлангийн хөгжүүлэлт хийгдсэн<br>*Захиргааны – 73 тайлангаас 61 тайлангийн хөгжүүлэлт хийгдсэн<br>*Албан ёсны – 20 тайлангаас 17 тайлангийн хөгжүүлэлт хийгдсэн<br>Бага, дунд боловсролын статистикийн мэдээллийг Монгол улсын үндэсний статистикийн хорооноос шинэчлэн баталсан маягт, аргачлал, зааврын дагуу шинэчлэн хөгжүүлж, улсын хэмжээнд системээр нэгтгэх ажлын хүрээнд тайлан бүрийн ангилал, үзүүлэлтийн шинжилгээ хийх, статистик тайлан тус бүрийн хувьд дүрэм бичих дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Тайлангийн дүрэм, тодорхойгүй үзүүлэлт тус бүрд дээр БШУЯ, БЕГ-н мэргэжилтнээс тодруулга авах, шийдэл боловсруулаа. 2022 оны мэргэжлийн чиглэлийн индекст өмнөх онуудын мэргэжлийн чиглэлийг дүйцүүлэх ажил хийгдлээ.Статистик тайлан тус бүрийн Template загварыг бэлтгэж, маягтын өөрчлөлттэй холбоотойгоор үндсэн системийн модул тус бүрт нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийсэн. Шинэчлэгдсэн маягтаар статистик тайланг гаргахтай холбоотойгоор Үндсэн систем буюу esis.edu.mn системд дараах нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийсэн. Үүнд:<br>*Боловсролын ерөнхий хуулийн шинэчлэлттэй холбоотойгоор сургалтын байгууллагуудын ангилал, төрлийн өөрчлөлтүүйг системд тусгаж, өөрчлөлттэй холбоотойгоор бусад холбогдох жагсаалтуудад өөрчлөлтийг тусгасаж хөгжүүлсэн.<br>* Ангилал, хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор сургалтын байгууллага шинээр үүсгэх процедурт өөрчлөлт орж, хөгжүүлэлт хийгдэв.<br>* Дараах модулиудад тайлангийн шинэ, үзүүлэлт ангилалуудыг тусгаж хөгжүүлэлт хийсэн | *70%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Байгууллага<br>- Суралцагч<br>- Багш, ажилтан<br>- Сургалтын орчин<br>- Байр, эд хөрөнгө<br>- 6-н асуулгын модулийг шинээр хөгжүүлсэн.<br>Шинэчлэгдсэн маягтаар улсын хэмжээнд тайланг нэгтгэх ажлын хүрээнд дараах сургалтуудыг БЕГ-тай хамтран зохион байгууллаа.<br>* БЗД-н сургалтын менежерүүдэд<br>* Баян-өлгийн аймгийн сургалтын менежерүүдэд<br>* 21 аймгийн сургалтын менежерүүдэд<br>- * 21-н аймаг, 9-н дүүргийн БШУГ, НБГ, БХ-н статистикийн мэргэжилтнүүдэд | |
| 1.8 | Техник мэргэжлийн боловсролын салбарын статистик тайлан нэгтгэлийн системийг хөгжүүлж, Монгол улсын үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, аргачлал, зааврын дагуу техникийн мэргэжлийн боловсролын статистикийн мэдээллийг цахим хэлбэрээр нэгтгэх боломжоор хангах | Улсын төсөв | - Шинээр хөгжүүлсэн статистик тайлангийн модулийн тоо<br>- Шинээр хөгжүүлсэн анхан шатны маягтын тоо<br>- Шинээр хөгжүүлсэн захиргааны маягтын тоо<br>- Шинээр хөгжүүлсэн албан ёсны маягтын тоо | Монгол улсын үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/137 тоот “Бага, дунд боловсролын болон техникийн мэргэжлийн боловсролын статистикийн мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг зөвшөөрч батлах, батлах тухай” тушаал батлагдсан. Техник мэргэжлийн боловсролын түвшинд статистик тайлан мэдээ цаасан суурьтайгаар нэгтгэн бүрдүүлдэг. | Техникийн мэргэжлийн боловсролын салбарын статистик тайлангийн системийг шинээр хөгжүүлсэн байна. Шинэчлэн батлагдсан техникийн мэргэжлийн боловсролын статистикийн анхан шатны 21, захиргааны 26, албан ёсны 16 буюу нийт 63 маягтын хөгжүүлэлтийг системд тусган тайлант үеүдэд шат дараатайгаар нэвтрүүлсэн байна. | Техник мэргэжлийн боловсролын статистик тайлангийн ангилал, үзүүлэлтэд шинжилгээ хийн шинээр хөгжүүлэх Техник мэргэжлийн боловсролын системийн ажлын даалгаварт тусгасан. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Боловсролын нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангах | Улсын төсөв | - Шинээр холбосон сургууль, хичээлийн байрны тоо<br>- Сүлжээний холболтын тогтвортой ажиллагааг хангасан сургууль, хичээлийн байрны тоо<br>Интернэт урсгалтын ашиглалтын хэмжээ /Mbps/ | 2022 онд боловсролын салбарын хэмжээнд 4000 Mbps интернэт урсгалыг боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдсон нийслэл хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудад хүргэн ажилласан. | Боловсролын нэгдсэн сүлжээнд шинээр ерөнхий боловсролын сургууль, хичээлийн байр холбох, боловсрол сургалтын байгууллагуудад интернэт үйлчилгээ үзүүлэн холболтын тогтвортой байдлыг хангаан ажилласан байна. | 2023 онд боловсролын салбарын хэмжээнд 4000 Mbps интернэт урсгалыг боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдсон нийслэл хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудад хүргэн ажилласан.<br>Тус ажлын хүрээнд:<br>- 4000Mbps интернэтийн урсгал<br>- Интернэт урсгалтын ашиглалтын хэмжээ /Mbps/ -7000<br>- 3901 тооны худаг, 488 тооны шилэн кабель<br>- 32 тооны цэгт 4G сүлжээ,<br>- 5 тооны цэгт Радио релей сүлжээ,<br>- 18 тооны цэгт VSAT сүлжээний тогтвортой байдлыг хангаж ажиллаа.<br>Шинээр сүлжээнд холбосон сургууль- 6, хичээлийн байрны тоо- 9 байна. Нийт 82 цэгт шилэн кабелийн засварын үйлчилгээ, 699 ерөнхий боловсролын сургуулийн сүлжээ, 1589 төхөөрөмжийн тогтвортой ажиллагааг хангаж интернэтийн үйлчилгээ үзүүлсэн.<br>Интернэт үйлчилгээ үзүүлж буйтай холбоотой 373 гомдол ирснээс 353 гомдлыг шийдвэрлэсэн байна. | *90%* |
| 1.10 | Боловсролын салбарын мэдээллийн систем, сүлжээ, серверийн өрөө, төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах | Улсын төсөв | - Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>- Зохион байгуулсан сургалтын тоо<br>- Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зөвлөмж хүлээн авсан. 2022 онд мэдээллийн аюулгүй байдлыг хангахтайгаар холбоотойгоор 5 удаа арга хэмжээ авсан.<br>Мэдээллийн систем болон өгөгдлийн сангийн 31ТВ өгөгдөл нөөцөлсөн. | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилтнуудад сургалт, заавар, зөвлөмж хүргүүлж, боловсролын мэдээллийн систем, санг нөөцөлсөн байна. | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилтнуудад нийт 2 удаагийн сургалт зохион байгуулж, 80 ажилтныг хамруулан холбогдох заавар, зөвлөмж хүргүүллээ. Салбарын хэмжээнд нөөцөлсөн систем, өгөгдлийн сангийн хэмжээ 71.1 /ТВ/ өгөгдлийг нөөцөлж, боловсролын мэдээллийн систем, сангийн нөөцийг бүрдүүлэн ажиллаа.<br>- Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хэрэгжүүлсэн арга хэмжээ 25<br>- Зохион байгуулсан сургалт 2<br>- Сургалтад хамрагдсан ажилтнууд 80<br>- Нөөцөлсөн систем, өгөгдлийн сангийн хэмжээ 71.1 /ТВ/ | *90%* |
| 1.11 | Боловсролын мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагаа, тогтвортой байдлыг хангах | Улсын төсөв | - Серверийн тоо<br>- Системийн тоо<br>- Өгөгдлийн сангийн тоо | Боловсролын мэдээллийн системийн 90 сервер, 14 сторэйж, 13 систем, 18 өгөгдлийн сан, 1661 сүлжээний | Боловсролын мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн ажиллагаа, тогтвортой байдлыг хангасан байна | Боловсролын мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн ажиллагаа, тогтвортой байдлыг бүрдүүлж нийт 90 сервер, 35 систем, 35 өгөгдлийн сан, 1624 сүлжээний төхөөрөмжийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангалаа.<br>Мэдээллийн системийн 260 виртуал сервер, 133/7800 под/ контэйнерийн хэвийн ажиллагааг мөн хангасан байна.<br>Боловсролын салбарын системын дата нөөцлөлтийг газар зүйн 2 байршилд хатуу дэд бүтцэд нэвтрүүлсэн. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Сүлжээний төхөөрөмжийн тоо<br>Виртуал сервер, под/ контэйнерийн тоо | төхөөрөмж, 275 виртуал сервер, 1069 подын тогтвортой байдал хангагдсан. | | | |
| 1.12 | Боловсролын салбарын албан хаагч хоорондоо мэдээ, мэдээлэл солилцох платформ боловсруулж нэвтрүүлэх боломжийг судлах | Улсын төсөв | Судалгааны баримт бичгийн тоо | Өмнө нь судалгаа хийгдэж байгаагүй. | Боловсролын салбарын албан хаагч хоорондоо мэдээ, мэдээлэл солилцох платформ боловсруулж нэвтрүүлэх боломжийг судалгаа хийсэн байна. | Боловсролын салбарын албан хаагч хоорондоо мэдээ, мэдээлэл солилцох платформ боловсруулж нэвтрүүлэх судалгааны хүрээнд Монгол улсад ашиглагдаж буй болон олон улсад ашиглагдаж буй системүүдийн судалгаа, харицуулалтыг хийж, ажлын даалгавар, санал зөвлөмжийг боловсруулсан.<br>Дараах системүүдийн судалгааг хийж, ерөнхий шаардлагыг гаргасан. Үүнд:<br>* Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia.mn/<br>* ERP /Enterprise resource planning/ систем<br>* Academia ERP<br>* Genius EDU<br>* Oracle ERP<br>Дээрх судалгаанаас харахад олон улсад ашиглагдаж байгаа систем гэхээсээ илүү Монгол улсын хэмжээнд нэвтрүүлэн ашиглагдаж байгаа системийг ашиглах нь зарим талаараа илүү давуу талтай байна. Жишээ нь: Ашиглалт, засвар сайжруулалтын зардал бага, зөвхөн боловсролын салбар гэлтгүй бүхий л төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцоход хялбар зэрэг давуу талуудтай байна. | *30%* |
| **Хоёр.Сургалтын цахим контент удирдлагын систем болон программ хангамжийн хөгжлийн асуудлын талаар** | | | | | | | |
| 2.1 | Цахим сургалтын платформ Medle.mn -ийн багш, суралцагчийн дэд системийн хэвийн, тогтвортой байдлыг хангах | Улсын төсөв | Сайжруулалт хийсэн модулийн тоо | Сургалтын цахим платформын bagsh.esis.edu.mn болон student.medle.mn системийг боловсролын салбарт ашиглаж байна. | Цахим контент удирдлагын системийг багш нь цахим сургалтын үйл ажиллагаа явуулах боломжтой байдлаар, суралцагчийн хувьд цахим сургалтад хамрагдах боломжтой байдлаар | Цахим контент удирдлагын системийг багш нь цахим сургалтын үйл ажиллагаа явуулах боломжтой байдлаар, суралцагчийн хувьд цахим сургалтад хамрагдах боломжтой байдлаар сайжруулан хөгжүүлж Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах боломжийг Суралцагч/student.medle.mn/ хичээл сонголт хийх, Анги удирдсан багш/bagsh.edu.mn/ сонголтыг хянах, баталгаажуулах, Сургалтын менежер/esis.edu.mn/ сургуулийн суралцагчдын хичээл сонголтыг хянах баталгаажуулах, Цахим сургууль нь суралцагчийн оношлох үнэлгээний /exam.edu.mn/ сорил, шалгалт зохион байгуулах системүүдүүдийн интеграци хийж сонгон судлах хичээлийг үндэсний хэмжээнд цахимаар зохион байгуулах менежментийн хөгжүүлэлтийг хийж ажиллаа.<br>2023-2024 оны хичээлийн жилд ахлах ангийн 16 сонгон судлах хичээлд сонголт хийсэн суралцагчдын цахим сургуулийн бүлэг, хичээлийн хуваарийг системд үүсгэсэн. Анги удирдсан багш, сургуулийн менежер, Цахим сургуулийн менежерүүдэд | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулан хөгжүүлсэн байна. | суралцагчдын ирцийн хяналт хийх тайлангийн модулиудыг шинээр хөгжүүлсэн ба цахим ангийн суралцагчийн Үнэлгээ 1, 2-ыг сургуулийн үнэлгээтэй нэгтгэж бодуулах зэрэг ажлуудыг хийж Сонгон судлах хичээлийг үндэсний хэмжээнд цахимаар зохион байгуулах цахим дэд бүтцийг бүрдүүлэн ажиллав. | |
| 2.2 | Ерөнхий боловсролын сургуулийн 10, 11 дүгээр ангийн сонгон судлах хичээлийн цахим сургалт зохион байгуулах | Улсын төсөв | - Сургалтад хамрагдсан суралцагчдын тоо<br>Сургалт зохион байгуулсан багшийн тоо | 2022-2023 оны хичээлийн жилд 21 аймаг 9 дүүргийн 10 дугаар ангийн 16 сонгон судлах хөтөлбөрөөр 10'409 суралцагч цахим сургалтад хамрагдаж байна. Цахим сургалтыг 20 менежер, 148 багшийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж байна. | 2023-2024 оны хичээлийн жилд сонгон судлах хөтөлбөрт хамрагдах суралцагчдын хичээл сонголтыг нэгтгэх, цахим анги бүлэг үүсгэх, хуваарь үүсгэх, цахимаар хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулсан байна. | Улсын хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 10,11 дүгээр ангийн суралцагчдын сонгон судлах 16 хичээлийн сонголтыг Суралцагчийн удирдлагын систем /student.medle.mn/ -ээр дамжуулан 2023 оны 05 сард урьдчилсан байдлаар, 2023 оны 09 сард сонгон суралцах байдлаар 2 удаа цахимаар зохион байгуулсан. 2023-2024 оны хичээлийн жилийн ахлах ангийн 16-н хичээлийн сонголтыг 10-р ангийн 43094, 11-р ангийн 37668 суралцагч хичээл сонголт хийжээ.<br>Сургууль дээр нь бүлэг бүрдээгүй 475 сургууль / нийслэл-119, аймгийн төв-114, сум-234, баг-7, Солонгос дах Монгол -1 сургууль/-ийн 10-р ангийн-9003, 11-р ангийн-6612 нийт 15615 суралцагч цахим сургуульд суралцаж ахлах ангийн сонгон судлах хичээлийг орон зай, байршлаас үл хамааран судалж байна.<br>2023-2024 оны хичээлд Medle цахим сургуульд 284 багш 10-р ангийн 575 бүлэг, 11-р ангийн 449 бүлэгт, давхардсан тоогоор 21544 сурагч хичээллэж байна.<br>Цахим сургуулийн Модуль1,2 сургалтад нийт 3182 багш хамрагдснаас 370 багш тэнцэж цахим сургуулийн шалгуурыг хангаж цахим сургуульд 284 багш сонгон судлах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хэл засал, дохионы хэлний багш нарын модуль сургалтын бүртгэл XI/01-XI/22-ны цахимаар явагдсан. Сургалт XI/27-XII/01 өдрүүдэд 5 хоног 14:00-16:30 цагийн хооронд "MS TEAMS" платформоор онлайнаар зохион байгуулагдаж сургалтад 235 багш бүртгүүлснээс 27 багш хамрагдсан, Насан туршийн боловсролын 517 багшид онлайн сургалт зохион байгуулсан.<br>- 2023-2024 оны хичээлийн жилд цахим сургуулийн багшаар ажиллаж байгаа багшийн тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэх зориолгоор 7 хоног бүрийн баасан, бямба гарагуудад онлайнаар 16-н судлагдахууны ахлах багш нар болон мэдлэ цахим сургуулийн менежерүүд 1 судлагдахуун 840 цагийн нийт 13440 цагийн сургалт зохион байгуулсан байна. | *100%* |
| 2.3 | Ээлжит хичээлийн цахим контент сонгон шалгаруулах, хүлээн авах, санд байршуулах | Улсын төсөв | - Санал ирүүлсэн хичээлийн тоо<br>- Оролцсон багшийн тоо | Ерөнхий боловсролын сургуулийн бүх судлагдахууны нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт, | Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, суралцахуйн удирдамжид | 2023 онд ЕБС-ийн 1-12 дугаар ангийн 5300 заавал судлах хичээлийн контентыг шалгаруулж санд байршуулахаар төлөвлөсөн ба 2023 оны 12 сарын 06-ны өдрийн байдлаар 4519 хичээл санд байршиж, 285 хичээлийн боловсруулалт дуусаж, зөвлөхийн сайжруулалт хийгдэж байна. Эрх олгосон 583 хичээл санд байршуулахаар боловсруулагчид сонгогдон ажиллаж байгаа нь оны эцэс гэхэд 5300 хичээлээ бүрэн санд авах боломжтой байна гэж дүгнэж байна. Энэ ажлын хүрээнд | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Үнэлгээ хийсэн хичээлийн тоо<br>- Эрх олгогдсон хичээлийн тоо<br>- Санд байршуулсан хичээлийн тоо<br>- Зохион байгуулсан сургалтын тоо<br>Сургалтад хамрагдсан багшийн тоо | зөвлөмж боловсруулагдсан, ЭХЦК-ын сонгон шалгаруулах үнэлгээний шалгуур, аргачлал батлагдсан.<br>2022 онд 4780 ээлжит хичээлийн цахим контент санд байршсан. | нийцүүлсэн 1-ээс 12 дугаар ангийн заавал судлах ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлсэн байна | Контентын сан хариуцах Үнэлгээний багийг Тендерийн сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлан зохион байгуулж бүрдүүлсэн.<br>2023 оны 04 сарын 01-ээс өнөөдрийг хүртэлх хугацаанд долоо хоног бүр тасралтгүй сонгон шалгаруулалтыг ерөнхий боловсролын багш бүрийг оролцох нээлттэй байдлаар ил тод зарлан мэдээлэл хүргэж ажилласан. Үнэлгээний баг гэрээт хугацаанд нийт 12000 гаран ээлжит хичээлд үнэлгээ хийж дүгнэлт бичсэн. Нийт санд байршсан эрх олгогдсон хичээлийг Монгол орны өнцөг булан бүрд байрлах ерөнхий боловсролын сургуульд хичээл зааж буй 900 багш манлайлан ажиллаж санд байршуулсан байна. Тус үйл ажиллагааны үр дүнд medle.mn контентын санг энэ онд 1,150,000 хэрэглэгч 21 сая удаагын хандалт хийсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 48% нэмэгдсэн байна. Өмнөх онд сурах бичгийн үзэлт хандалт их байсан бол Ээлжит хичээлийн контентын хандалт 60% нэмэгдсэн хамгийн их үзэлттэй контент болсон байна. Мөн ээлжит хичээлийн контентод агуулгын залгамж холбоогоор хамааралтай сурах бичгийн хуудас, теле хичээл, интерактив контентуудыг холбох шаардлагыг боловсруулагчаас шаардлаж байгаа тул Мэдлэ сангийн контент бүхэлдээ эргэлтэд орж бүрэн ашиглагдаж байгаа онцлогтой. | |
| **Гурав.Боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх талаар** | | | | | | | |
| 3.1 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх системийг хөгжүүлэх | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо<br>Цахимаар ирсэн хүсэлтийн тоо | Цэцэрлэгт элсэх хүсэлт илгээх, хүсэлтийн хариу хүлээх авах зэрэг нийт 4-н үйлчилгээг ХУР системээр дамжуулан И-Монголиа академитай хамтран хөгжүүлж, элсэлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлт 1-р шатанд 58,505, 2-р шатанд 20,236, 3-р шатанд 6,535 хүсэлт ирснээс 107,337 хүүхдийн | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчийн элсэлтийн цахим бүртгэлийг үе шаттайгаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх элсэлтийн модулийн сайжруулалтыг хийж, тогтвортой байдлыг хангасан байна. | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоол, “Нийслэлийн цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийг зохион байгуулах түр журам” А/81 тоот тушаалаар цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулна гэж заасны дагуу элсэлтийн бүртгэл үйл ажиллагааг И-Монголиа академитай хамтран 2 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа.<br>Нэгдүгээр шатны хүсэлт хүлээн авах үйл ажиллагаа 2023.08.01-2023.08.20-ны хооронд, хоёрдугаар шатны хүсэлт хүлээн авах үйл ажиллагаа 2023.09.11- 2023.09.20-ны хооронд e-mongolia.mn болон elselt.esis.edu.mn -р зохион байгуулсан ба нийт 124306 хүүхдийг цэцэрлэгт хамруулах хүсэлт цахимаар ирсэн. Цахимаар ирүүлсэн хүсэлтээс гадна 10625 хүүхдийг элсүүлэх хүсэлт уламжлалт хэлбэрээр бүртгэсэн мэдээлэл Нийслэлийн боловсролын газраас ирж нийт 134931 хүсэлтийг хүлээн авсан. Түр журмын 2.8 дах заалтын дагуу элсэлтийн хувиарлалтыг системээр шийдвэрлэх боломжийг ажлын хэсэгт бүрдүүлж өгсөн. Шийдвэрлэсэн мэдээллийг мэдээллийн санд нэгтгэж, эцэг, эх, асран хамгаалагчдад хүсэлт ирүүлсэн сувгаар /E-mongolia.mn/, parent.edu.mn болон бүртгэлтэй гар утасны дугаараар мессеж хүргүүлэн мэдэгдэх ажлыг зохион байгуулж ажиллаа. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүсэлтийг энэхүү үйлчилгээгээр дамжуулж цэцэрлэгт хуваарилсан. | | | |
| 3.2 | Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх системийг хөгжүүлэх | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо<br>Цахимаар ирсэн хүсэлтийн тоо | Төрийн өмчийн ерөнхий боловсролын нэгдүгээр ангид элсэх 31,793 иргэний хүсэлтийг И-Монголиа системээр хүлээн авч баталгаажуулсан. | Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх элсэлтийн системийн сайжруулалтыг хийж, тогтвортой байдлыг хангасан байна. | . Төрийн өмчийн ерөнхий боловсролын нэгдүгээр ангийн элсэлтийн үйл ажиллагааг 2023.08.07-2023.08.11-ны хооронд И-Монголиа академитай хамтран амжилттай зохион байгуулсан. Нэгдүгээр ангийн элсэлтийн үйл ажиллагааг e-mongolia.mn болон esis.edu.mn /дэмжих систем/-р зохион байгуулсан ба нийт 38463 хүүхдийн хүсэлтийг цахимаар хүлээн авсан. Уг үйл ажиллагааны хүрээнд И-Монголиа академид 1-р ангийн элсэлтийн бодлогын даалгаврыг гарган хүргүүлж, esis.edu.mn системд хамран сургах тойрог тохируулах, сургалтын байгууллага элсэлтийн урьдчилсан бүртгэл хийх, сургуулийн элсэлтийн комисс элсэгчийг анги бүлэгт хувиарлах боломж нөхцлийг бүрдүүлж ажилласан. Мөн parent.edu.mn системээр дамжуулан нийтэд 1-р ангийн цахим бүртгэлийн мэдээ, мэдээллийг байршуулж, иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан байна. | *100%* |
| 3.3 | Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн 4-н ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийг бүртгэлийг цахимаар зохион байгуулах; | Улсын төсөв | - Хөгжүүлэлт хийсэн модулийн тоо<br>Цахимаар ирсэн хүсэлтийн тоо | Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн 4-н ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийг бүртгэлийг цахимаар зохион байгуулж байгаагүй, судалгаа хийж, шинээр хөгжүүлэх шаардлагатай. | Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн 4-н ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн цахим бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх элсэлтийн системийн судалгааг хийж, хөгжүүлж, тогтвортой байдлыг хангасан байна. | ОУХ-тэй гурван сургуулийн төлөөлөлтэй хэд хэдэн удаагийн уулзалт зохион байгуулж элсэлтийн цахим бүртгэлийн системийг хөгжүүлэх ажлын цар хүрээ, шаардлагыг тодорхойлсон. 2023-2024 оны хичээлийн жилд ОУХ-тэй сургуулиудын элсэлтийн үйл ажиллагааг Боловсролын үнэлгээний төв хариуцан системийн хөгжүүлэлтийг хийж, уг системээр элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан ба уг үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай сервис мэдээллүүдийг хөгжүүлж БҮТ-д хүргүүлсэн. | *30%* |
| 3.4 | Боловсролын төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Нэмэгдсэн үйлчилгээний тоо | ЕБС-ийн суурь, бүрэн дун боловсролын гэрчилгээ, дээд боловсролын | “Оюутан цэрэг 2023” цахим үйлчилгээний бүртгэл, БШУЯ-наас олгодог | * “Оюутан цэрэг 2023” бүртгэлийг БХЯ, БШУЯ, ҮДТ, И-Монголиа академитай хамтран зохион байгуулж, 2023 онд 1200 орчим хүсэлтийг И-Монголиа системээр хүлээн авч 1000 гаран хүсэлтийг шийдвэрлэсэн байна. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалтын байгууллагын дипломын лавлагаа, боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа тухай тодорхойлолт болон ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар, ЭЕШ-н дүн оноо лавлагаа гэсэн 6 төрлийн лавлагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна | боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Оюутан цэрэг 2023 бүртгэлд ЗГ-ын 32-р тогтоолд заасан шалгуурыг хангасан, дээд боловсролын мэдээллийн системд бүртгэлтэй суралцагчид хамрагдсан ба уг шаардлагыг хангасан оюутнуудын мэдээллийг хүргүүлэх сервисийн сайжруулалтыг хийсэн. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагуудад оюутан цэргийн бүртгэлтэй холбоотой зар мэдээлэл өгч, суралцагч, голч дүнгийн мэдээлэл системд оруулах талаар заавар зөвлөгөө өгөн ажилласан. Оюутан цэргийн цахим бүртгэлийн хүрээнд өдөр бүр шалгуур хангасан оюутны сургууль, хөтөлбөр, голч дүнгийн мэдээллийг Үндэсний Дата Төв рүү дамжуулан өгч цахимаар бүртгэл хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллав.<br>* Олон улсын хөтөлбөрийн сургалттай ЕБС, ерөнхий боловсролын лаборатори сургууль, их, дээд сургуулийн харъяа ЕБ-ын ахлах сургууль, ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль болон гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг цахимаар хүлээн боломжтойгоор хөгжүүлэлтийг хийн нэвтрүүлсэн. | |
| 3.5 | Боловсролын салбарын мэдээллийн системийн оюутан, суралцагчийн мэдээлэл солилцох сервисийг дүн үнэлгээ, төлбөрийн мэдээллийг солилцох боломжтой болгон сайжруулж, идэвхжүүлэх | Улсын төсөв | Шинээр хөгжүүлсэн сервисийн тоо | Боловсролын салбарын мэдээллийн сан болон салбарын мэдээлэл солилцооны системд тулгуурлана. | Шаардлагатай үйлчилгээний судалгааг хийж, мэдээлэл солилцооны сервис хөгжүүлсэн байна. | Дээд боловсролын 24 сервисийг back end-н сүүлийн хувилбарт нийцүүлэн дахин хөгжүүлж, шинэчлэгдсэн хувилбараар developer.esis.edu.mn систем дээр байршуулж, мэдээлэл солилцох орчин нөцлийг бүрдүүлж ажилласан. | *100%* |
| 3.6 | Боловсролын салбарын мэдээллийн системийн багш, | Улсын төсөв | Шинээр хөгжүүлсэн сервисийн тоо | Боловсролын салбарын мэдээллийн сан болон салбарын | Шаардлагатай үйлчилгээний судалгааг хийж, мэдээлэл | Багш карт, оюутан карт, оюутны автобусны карт захиалах, оюутан цэрэг 2023, суурь, бүрэн дунд боловсрол, их, дээд боловсролын лавлагаа, суралцаж байгаа тодорхойлолт, нийслэлийн цэцэрлэгт хамрагдах зэрэг үйлчилгээнүүдийг ХУР | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилтны мэдээлэл солилцох сервисийг ХУР системд байршуулах | | | мэдээлэл солилцооны системд тулгуурлана. | солилцооны сервис хөгжүүлсэн байна | төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан иргэдэд хүргэж байна.<br>Үүнд: Үйлчилгээний нэр 2023.01.01-2023.11.29<br>1 Бүрэн дунд боловсролын үнэмлэхийн тодорхойлолт - 29897 иргэн авсан<br>2 Дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт - 116923 иргэн авсан<br>3 Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа тодорхойлолт - 38469 иргэн авсан<br>4 Суурь боловсролын гэрчилгээний тодорхойлолт - 4670 иргэн авсан<br>5 Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлт - 140036<br>6 Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлт 2 - 18428<br>7 Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлтийн үр дүн - 133189 иргэнд хүргэсэн.<br>8 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэл - 28942<br>9 Оюутны автобусны карт захиалах (Шинэ карт захиалах) - 24372<br>10 Багш карт - 2024412 хандалт<br>11 Оюутан карт - 16686112 хандалт хийгдсэн байна. | |
| 3.7 | Олон улсын хандивлагч, донор байгууллага нэг дороос нэгдсэн байдлаар боловсролын салбарын мэдээ, мэдээлэл авах, өөр хоорондоо мэдээлэл солилцох боломжтой “Mongolia Local Education Group” вэбсайт хөгжүүлэх судалгаа хийх | Улсын төсөв | Судалгаа хийсэн баримт бичгийн тоо | Өмнө нь судалгаа хийгдэж байгаагүй. | Олон улсын хандивлагч, донор байгууллага нэг дороос нэгдсэн байдлаар боловсролын салбарын мэдээ, мэдээлэл авах, өөр хоорондоо мэдээлэл солилцох боломжтой “Mongolia Local Education Group” вэбсайт хөгжүүлэх судалгаа хийсэн байна. | Тухайн онд боловсролын салбарт хийж хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн үйл ажиллагаануудыг нэгдсэн нэг талбараас харах, тухайн үйл ажиллагааг зохион байгуулагч, оролцогч, эхлэх болон дуусах хугацаа, давтамж зэргийг нээлттэй, хялбар ойлгомжтой харуулах зорилготой системийн судалгаа бизнес шаардлага баримт бичгийг боловсруулан гаргасан.<br>Энэхүү систем нь олон нийтэд нээлттэй бөгөөд мэдээлэл оруулах удирдлагын хэсэгтэй байна.<br>Систем нь дараах 2 төрлийн хэрэглэгчтэй байна.<br>• Системийн зохицуулагч нь удирдлагын дэд модулийг ашиглан цахим цагалбарт байгууллагын бүртгэл хөтлөх, үйл явдал шинээр оруулах, засварлах, устгах, нийтлэх үйл ажиллагааг гүйцэтгэх боломжтой байна. Энэ төрлийн хэрэглэгч нь нэвтрэх нэр, нууц үгээр удирдлагын хэсэгт нэвтэрч системийг ашиглах боломжтой байна.<br>• Энгийн хэрэглэгч нь цахим цагалбарын системд ямар нэгэн нэвтрэх нэр, нууц үг ашиглахгүйгээр нийтлэгдсэн мэдээллийг https://calendar.edu.mn/ хандан нээлттэй, шууд хандах боломжтой байна. | 100% |
| 3.8 | Гадаад улсад сурч, ажиллаж буй иргэдийг Монгол Улсын боловсролын | Улсын төсөв | Судалгаа хийсэн баримт бичгийн тоо | Өмнө нь судалгаа хийгдэж байгаагүй. | Гадаад улсад сурч, ажиллаж буй иргэдийг Монгол Улсын | МУ-ын засгийн газраас шалгаруулан бусад улс орны засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутнуудыг Монгол Улсын боловсролын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг олгох, тэдгээрийг мэдлэг, ур чадварыг татах, мэдээлэл хуваалцах зорилго бүхий “E-Bee” платформыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг олгох, тэдгээрийг мэдлэг, ур чадварыг татах, мэдээлэл хуваалцах зорилго бүхий “E-Bee” платформыг боловсруулж нэвтрүүлэх боломжийг судлах | | | | боловсролын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг олгох, тэдгээрийг мэдлэг, ур чадварыг татах, мэдээлэл хуваалцах зорилго бүхий “E-Bee” платформыг боловсруулж нэвтрүүлэх боломжийг судалсан байна. | боловсруулж нэвтрүүлэх боломжийг судлан Medle.mn-д подкаст булангийг нээн ажиллуулах судалгааны ажлыг хийв. | |
| **Дөрөв. Боловсролын салбарын мэдээллийн системийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тогтвортой ажиллагааг хангах талаар** | | | | | | | |
| 4.1 | Сургуулийн өмнөх боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Сургуулийн өмнөх боловсролын салбарын мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд ашиглаж байна. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | Сургуулийн өмнөх боловсролын салбарын суралцагчийн бүртгэл, анги солих, түвшин солих, баталгаажуулах хүсэлт илгээх, хасах зэрэг нэгж дээр хийгдэх үйл ажиллагаа, БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ, БХ зэрэг дээд шатны байгууллага дээрх хяналт, баталгаажуулалт, нэгтгэл тайлан харах зэрэг үйл ажиллагааны системийн тогтвортой ажиллагааг хангаж ажилласан.<br>- Мөн сургуулийн өмнөх боловсролын салбарын статистик тайлан мэдээг тайлант үе болгоноор тайлангийн загвар бэлтгэх, тестийн орчинд тайлан нэгтгэл гаргах хэвийн ажиллагааг шалгаж бодит орчинд нийт байгууллага, ажилтан суралцагчийн 15 маягт бүхий тайлан, Сургалтын орчин, ус ариун цэврийн 4 маягт бүхий тайлан, Төсвийн гүйцэтгэл болон нийт хөрөнгөтэй холбоотой 4 маягт бүхий тайлан зэрэг 3 тайлант үеийн нийт 23 маягтыг нэгж дээр нээж тайланг хуулийн хугацаанд нь нэгтгэн авсан. Үүнээс гадна албан тайлан буюу Үндэсний статистикийн хороонд өгдөг албан 4 маягт бүхий тайлан, БШУЯ-д 12 маягт бүхий ном тайлан нийт 39 маягт бүхий тайланг товлосон цаг хугацаанд нь системээр нэгтгэн авах боломжоор хангаж ажилласан. Дээрх үйл ажиллагаануудын хүрээнд өдөр бүр дуудлага мэдээллийг хүлээн авч, гарч буй асуудлуудыг шийдвэрлэж, шаардлагатай сайжруулалтыг системд хөгжүүлж, системийн гарын авлага, заавар зөвлөгөөг боловсруулсан | *100%* |
| 4.2 | Бага, дунд боловсролын салбарын | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо | - Ерөнхий боловсролын салбарын | - Сайжруулалт хийсэн модулийн тоо | *Ерөнхий боловсролын суралцагчийн бүртгэл, анги солих, түвшин солих, баталгаажуулах хүсэлт илгээх, хасах зэрэг нэгж дээр хийгдэх үйл ажиллагаа, БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ, БХ зэрэг дээд шатны байгууллага дээрх хяналт, баталгаажуулалт, | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах | | Боловсруулсан гарын авлагын тоо | мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд ашиглаж байна. | Боловсруулсан гарын авлагын тоо | нэгтгэл тайлан харах зэрэг үйл ажиллагааны системийн тогтвортой ажиллагааг ханган ажилласан байна.<br>*Боловсролын ерөнхий хуулийн шинэчлэлттэй холбоотойгоор сургалтын байгууллагуудын ангилал, төрлийн өөрчлөлтүүйг системд тусгаж, өөрчлөлттэй холбоотойгоор бусад холбогдох жагсаалтуудад өөрчлөлтийг тусгасаж хөгжүүлсэн.<br>- Өмчийн хэлбэрийн өөрчлөлт<br>- Сургуулийн хэв шинжийн өөрчлөлт<br>- Ангилалын өөрчлөлт<br>-Ангилал, хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор сургалтын байгууллага шинээр үүсгэх процедурт өөрчлөлт орж, хөгжүүлэлт хийгдсэн<br>*Шинэчлэгдсэн статистик маягтыг улсын хэмжээнд нэгтгэн гаргах ажлын хүрээнд дараах модулиудад тайлангийн шинэ, үзүүлэлт ангилалуудыг тусгаж хөгжүүлэлтийг хийсэн байна.<br>- Байгууллага<br>- Суралцагч<br>- Багш, ажилтан<br>- Сургалтын орчин<br>- Байр, эд хөрөнгө<br>- 6-н асуулгын модулийг шинээр хөгжүүлсэн.<br>*Мэдээлэл солилцооны ажлын хүрээнд багшийн системийн цахим журналын модулиудыг хааж, холбогдох сервис мэдээллийн хөгжүүлэлтүүдийг хийж, сервисээр ирсэн мэдээллийг системд харуулах ажлын хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Дээрх үйл ажиллагаануудын хүрээнд өдөр бүр дуудлага мэдээллийг хүлээн авч, гарч буй асуудлуудыг шийдвэрлэж, шаардлагатай сайжруулалтыг системд хөгжүүлж, системийн гарын авлага, заавар зөвлөгөөг боловсруулж, 21-н аймаг, 9-н дүүргийн мэргэжилтнүүдэд, сургалтын байгууллагын менежерүүдэд сургалт зохион байгуулж ажилласан. | |
| 4.3 | Мэргэжлийн боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо<br>Боловсруулсан гарын авлагын тоо | Техник болон мэргэжлийн боловсролын салбарын мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд ашиглаж байна. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | Системийн тогтвортой ажиллагааг хангах, 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөлт болон тэтгэлэг олголтын үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>* Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 122 дугаар тогтоолоор Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журамд нийцүүлэн тэтгэлэг олголтын модулийг төгсөх үед нь нэг удаа олгодог байдлаар хөгжүүлсэн ба тэтгэлэг олголтын мэдээллийг системд импорт хийх боломжтой болгосон.<br>* БШУ-ны сайдын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/278 тушаалаар Мэргэжлийн боловсролын 2,5 жилийн сургалтын хугацааг 3 жил болгож агуулгад өөрчлөлт оруулсны дагуу Техник, мэргэжлийн боловсролын удирдлагын мэдээллийн | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтвортой ажиллагаа хангах | | | | | системд мэргэжлийн боловсролын хичээлийн жилийн хугацааг 3 жил болгон хөгжүүлсэн.<br>* E-Mongolia системд ТМБ-н салбарын суралцагчийн мэдээллийг дамжуулан Автобусны карт захиалах үйлчилгээг нэвтрүүлсэн<br>* Техник, мэргэжлийн боловсролын удирдлагын мэдээллийн системд 15.593 суралцагчийн тэтгэлгийн мэдээллийг баталгаажин олгогдсон<br>*Техник, мэргэжлийн боловсролын удирдлагын мэдээллийн системээр боловсролын баримт 18.583 хэвлэсэн.<br>*ТМБ-н системтэй холбоотой дуудлага мэдээллийг хүлээн авч шийдвэрлэж ажилласан ба цаг үетэй холбоотой мэдээ, мэдээллийг холбогдох группүүдэд байршуулж, заавар зөвлөгөөг өгч ажилласан.<br>- БШУ-ны сайдын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/284 дугаар тушаал батлагдан тус ажлын хэсгийн хүрээнд БМТТ УТҮГ нь "Суралцахуйн удирдлагын мэдээллийн систем- U-TVET, Багаж эд хөрөнгийн бүртгэлийн систем- TAMS" системүүдийн судалгаа шинжилгээ хийж хүлээн авахад шаардлагатай дүгнэлт гаргаж, бэлтгэл хангах ажлын хэсгийг БМТТ УТҮГ-ын захирлын 2023 оны 09 сарын 25-ны өдрийн А/86 тушаалын дагуу дүгнэлт гарган БШУЯ-д хүргүүлэн ажилласан | |
| 4.4 | Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн модулийн сайжруулалт, статистик тайлан нэгтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллагаа хангах | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд ашиглаж байна. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | 2023 онд Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн тогтвортой ажиллагааг хангаж, статистик тайлан мэдээг хуулийн хугацаанд нэгтгэн гаргав. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн жагсаалт шинэчлэгдэж, БШУ-ны сайдын А/97 тушаалаар хөтөлбөрт элсүүлэх шалгуур өөрчлөгдөж шинэчлэгдсэнтэй холбогдуулан шаардлагатай хөгжүүлэлтийн ажлуудыг төлөвлөн цаг тухай бүрд хийлгэж, 2023-2024 оны хичээлийн жилд шинэ суралцагчдыг элсүүлэн, тайлан мэдээг нэгтгэн гаргаж өглөө. | *100%* |
| 4.5 | Сургуулийн өмнөх боловсролын хичээлийн жилийн хаалтын дэвшилт, төгсөлтийн бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Сургуулийн өмнөх боловсролын салбарын мэдээллийн системд суралцагчийн шилжилт хөдөлгөөн, дэвшилтийн бүртгэл, төгсөлтийн | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | 2022-2023 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх боловсролын дэвшилт, төгсөлтийг системээр хийж, улсын хэмжээнд 185000 гаруй хүүхэд дэвшиж, 75570 хүүхэд төгссөн байна. Энэхүү ажлын хүрээнд дэвшилт, төгсөлтийн холбогдох тохиргоонуудыг системд үүсгэн, системийн хэвийн үйл ажиллагаанд дэмжлэг, зөвлөгөө өгөн ажилласан байна. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх | | | бүртгэл, хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүртгэж баталгаажуулдаг. | | | |
| 4.6 | Ерөнхий боловсролын хичээлийн жилийн хаалтын дэвшилт, төгсөлтийн бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн системд жилийн эцсийн дүн, дэвших шалгалтын дүн, улсын шалгалтын дүн, судлагдахууны дүн /9, 12-р анги/, үнэт цаас хуваарилалт, үнэмлэх, гэрчилгээ хэвлэлт, дэвшилтийн бүртгэл, төгсөлтийн бүртгэл, хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүртгэж баталгаажуулдаг. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | 2022-2023 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын дэвшилт, төгсөлт болон боловсролын баримт бичгийг системээр олгон улсын хэмжээнд 585000 гаруй хүүхэд дэвшиж, 167000 гаруй хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг төгсөж, 94000 гаруй хүүхдэд суурь болон бүрэн дунд боловсрлын баримт бичгийг системээр хэвлэн олгосон байна. Энэхүү ажлын хүрээнд монгол бичиггүй сургалтын байгууллага, хүүхдийн нэрсийг БЕГ, МУИС -ын багш нартай хамтран хөрвүүлж, хичээлийн жилийн бүтэц, улсын болон дэвших шалгалт, судлагдахуун зэрэг тохиргоонуудыг системд үүсгэн улсын хэмжээнд дэвшилт, төгсөлт, баримт бичиг олголтыг бүрэн хийж дууссан. Мөн холбогдох дуудлага мэдээллийг хүлээн авч авч, менежер, аймаг, дүүргийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөн ажилласан. | *100%* |
| 4.7 | Техник болон мэргэжлийн боловсролын элсэлт, төгсөлт, баримт бичиг олголт, тэтгэлэг олголтын суурь бүртгэлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хүлээн авсан мэргэжлийн болон техникийн боловсролын mergejil.mn -ийг tvets.edu.mn хаяг дээр тогтвортой байдлыг ханган ажиллуулж байна. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | - 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын төгсөлтийн үйл ажиллагаатай уялдуулан сургалтын байгууллагуудын системд бүртгэлтэй суралцагчдын ирц, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, тэтгэлэг олголтын явцыг хянан дэмжлэг туслалцаа үзүүлэн гарсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан. Нийт 76 сургуулийн 19197 хүүхэд дэвшиж, 19940 хүүхэд техник, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгссөн байна. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх | | | | | | |
| 4.8 | Дээд боловсролын элсэлт, төгсөлт, баримт бичгийн дугаар хуваарилалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай сайжруулалтыг системд тусган хөгжүүлэлт хийж, нэвтрүүлэх | Улсын төсөв | - Сайжруулалт хийсэн модулийн тоо Боловсруулсан гарын авлагын тоо | Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийг ашиглан элсэлт, төгсөлт, баримт бичгийн дугаар хуваарилалтын үйл ажиллагааны бүртгэлийг төрийн болон хувийн өмчийн бүх сургалтын байгууллагууд хөтлөн явуулж байна. | Шаардлагатай сайжруулалтын санал боловсруулан, хөгжүүлэлт хийж тогтвортой ажиллагааг хангасан байна. | 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын төгсөлтийн үйл ажиллагаатай уялдуулан дүн, үнэлгээ, дипломын дугаар захиалга, дугаар хувиарлалт, төгсөлт, импорт, сервис солилцоо зэрэгт дэмжлэг туслалцаа үзүүлэн гарсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан. | *100%* |
| **Тав. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын талаар** | | | | | | | |
| 5.1 | Салбарын бодлого, төлөвлөлттэй холбоотой болон шинээр батлагдсан хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангаан ажиллах, | Улсын төсөв | Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын тоо | Хууль дүрмийн заалтаар хүлээсэн үүргийн дагуу | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын мэдээллийн сан үүсгэн, албан хэрэгцээнд ашигласан байна. | Салбарын бодлого, төлөвлөлттэй холбоотой хууль тогтоомж, шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/07 дугаар "Хөтөлбөр, арга хэмжээний 2023 оны төсвийн хуваарилалт батлах, эрх шилжүүлэх тухай" тушаалын дагуу:<br>-"Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим сургалтын платформын мета хувилбарыг хөгжүүлэх, системд контент хөгжүүлэлтийн зөвлөх багш нар ажиллуулах зардал"-ын хүрээнд худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг 2023.03.27, 2023.04.07, 2023.05.16-нд тус тус зарлаж шалгаруулалт тус бүр дээр хууль тогтоомжийн дагуу үнэлгээ хийж шалгаруулан нийт 33 багц үйлчилгээнд зөвлөх багш нартай 2023.12.31-ийг дуустал хугацаагаар гэрээ байгуулан ажиллаж байна.<br>-Цахим сургуулийн мета хийсвэр хувилбар хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа 2023.11.27-нд тендерийн нээлт хийж, хуулийн хугацаанд үнэлгээ хийх ажил хийгдэж байна.<br>-Цахим сургалт зохион байгуулах багш нарын ур чадварыг дээшлүүлэх модуль сургалтыг Улаанбаатар хот, орон нутгийн нийт 300 багш нарт 2023.11.27-2023.12.03-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж байна. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Цахим сургалтын багшийн техник хэрэгсэл худалдан авах арга хэмжээний хүрээнд 101 ширхэг зөөврийн компьютерыг 2023 оны 9,10 дугаар сард худалдан авах ажиллагааны ерөнхий гэрээний зарчмаар худалдан авсан.<br>-"Цахим шилжилт, арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн цахим контент бүтээх зардал"-ыг хэрэгжүүлэх хүрээнд төвийн захирлын 2023.4.10-ны өдрийн А/18 дугаартай "Зардал батлах тухай" тушаалыг баталж, Контент бүтээгч багш нартай байгуулсан "Контентийн онцгой эрх шилжүүлэх гэрээ"-ний дагуу сар бүрийн гүйцэтгэлээр нь холбогдох төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн ажиллаж байна.<br>2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/108 дугаар ""Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-ын бүтэц, цалин хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын хүрээнд төвийн зохион байгуулалтын нэгжүүдийг шинэчлэн нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт шинэчлэн баталж хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.<br>3.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/134 дугаар тушаал, БШУЯ-ны 2023 оны 8/4404 дугаар албан бичгийн хүрээнд холбогдох ажлын гүйцэтгэлийн мэдээлэл тайланг сар бүрийн 15-ны өдөр тайлагнаж байна.<br>4.БШУЯ-ны Д.А.Хорооны 2023.5.02-ны өдрийн №3 дугаартай тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч 2023.6.15-ны өдрийн 1/207 дугаартай албан бичгээр биелэлтийг хүргүүлсэн.<br>5. БШУ-ны сайдын 2023.8.21 өдрийн А/336 дугаартай тушаалын хэрэгжилтийг хангуулан 2023.10.02-ны өдрийн А/87 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаал батлан, сайдын тушаалд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр Хөлсөөр ажиллах гэрээг 9 иргэнтэй байгуулж, томилогдсон ажлын хэсгээр дамжуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | |
| 5.2 | Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, | Улсын төсөв | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах | - | | • Төвийн нийт ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажлын бүтээмжтэй ажиллуулах, ажлын чиг үүргийг тодруулах, өдөр тутмын ажлын үр дүнг бодитой болгох зорилгоор тус төвийн захирлын 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн Б/25 тоот тушаалаар ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлан нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн хийлээ.<br>• БШУЯ-ны Дотоод аудитын хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу БШУС-ын баталсан бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг баримтлан ажиллах, бусад нэмэгдлүүдийг олгохдоо холбогдох дүрэм журмыг баримтлах зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусган шинэчлэх, зарим албан хаагчдын цалин бууруулсан асуудлыг шийдвэрлэж, өмнө авч байсан цалингийн хэмжээгээр тушаалд өөрчлөлт оруулах зэрэг ажлууд хийгдлээ.<br>• БМТТ-ийн албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг, ажлын ачаалал, ажлын гүйцэтгэл, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, ажилтнуудын нийгмийн баталгааг, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор ажлын байрны нөхцөл байдлын шинжилгээг хийн ажилласан.<br>“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" hrm.csc.gov.mn цахим системд нийт албан хаагчдын ажилд томилогдсон томилгооны үндэслэл, өөр байгууллагад ажилласан түүх, дотоод хөдөлгөөний түүх, яаралтай үед холбоо барих ажилтны мэдээлэл зэрэг дэлгэрэнгүй хувийн мэдээллийг шинэчлэн, тухай бүр нь оруулан ажиллаж байна.Албан хаагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр:<br>• Хувийн санхүү, өрхийн орлого төлөвлөх /сургагч багш Оюун/<br>• Байгууллагын хөгжлийн загвар/ Удирдлагын академи доктор Т. Ганбаатар/<br>• Байгууллагын соёл, баг хамт олон бүрдүүлэх нь /Удирдлагын академи доктор Н.Төмөр/<br>• Мэдээллийн аюулгүй байдал /Ариунболд, Төгөлдөр/ сургалтуудыг зохион байгуулж, долоо хоног бүрийн 4 өдөр чийрэгжүүлэлтийн арга хэмжээг явуулж хэвшсэн. | |
| 5.3 | Төсөв санхүүг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй зарцуулж, мэдээ тайланг цаг хугацаанд нь дээд шатны байгууллагад тайлагнах, шилэн дансны хууль, батлагдсан төсөв, гүйцэтгэлийг ил | Улсын төсөв | Төсвийг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй төсөв, гүйцэтгэлийг ил тод, хугацаанд нь тайлагнах | Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Шилэн дансны хуулийн дагуу | Эхний хагас жилд:<br>-<br>Жилийн эцэст: Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангаж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нийгмийн даатгал, татвар зэрэг тайлангуудыг хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнаж, дээд шатны байгууллагад хүргүүлж мөн шилэн дансны тухай хуулийн дагуу хагас жилийн туршид санхүүгийн мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлж ажиллаж байна.<br>• 2023 оны эхний 10 сарын байдлаар худалдан авсан бараа ажил үйлчилгээ үзүүлэх 949 гэрээ байгуулагдаж 5,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий 765 гэрээг | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тодоор цахим сүлжээнд байршуулан хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж баталгаажуулах | | | | | тухайн сард нь шилэн дансанд байршуулсан.<br>• 2023 онд хийгдсэн 815,020.0 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх 33 гэрээнд 310,691.4 мянган төгрөгийг , 216,500.0 мянган төгрөгийн контент худалдан авах 294 гэрээнд 203,105,0 мянган төгрөгийг, 44,052.9 мянган төгрөгийг хөлсөөр ажиллах 27 гэрээнд 105,458.2 мянган төгрөгийн /зарим гэрээний дүн сарын хөлсөөр хийгдсэн/, өмнөх онд хийгдсэн гэрээ сунгагдсантай холбоотой 142 гэрээнд 52,513,8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн худалдан авалт, оффис түрээс, интернэт үйлчилгээ, программ хангамж ашиглалт, цахим сургуультай холбоотой, үнэлгээ статистик хариуцсан менежер ажиллуулах гэх мэт гэрээнүүдтэй холбоотой зардалд 916,868,0 мянган төгрөг зарцуулсан<br>• Худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2023 онд хэрэгжүүлэхээр 5 төсөл хөтөлбөрийн төлөвлөснөөс 2 төсөл хөтөлбөр шалгаруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. | |
| 5.4 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах | Улсын төсөв | Баримт бичиг гүйцэтгэл, шийдвэрлэлтийн хувь | Архив, албан хэрэг хөтлөлийн хууль, дүрэм | Эхний хагас жилд:<br>-<br>Жилийн эцэст: Байгууллагын архивын баримт бичгийг стандартын дагуу бүрдүүлсэн байна | - Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандартын дагуу төвийн баримт бичгийг зохион бүрдүүлэн ажиллаж байна.<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн ERP программд ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүрд нь бүртгэж холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. Мөн ERP системд холбогдсон зарим төрийн байгууллагуудад яаралтай албан тоотыг хүргүүлэх, хүлээн авах ажлууд хийгдэж байна.<br>- 2023 оны 12-р сарын 06-ны байдлаар нийт **151** албан бичиг ирж, **378** албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлж албан хэрэг хөтлөлтийн стандарт заавар журмын дагуу бүртгэж ажилласан. Үүнээс ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж, хугацаанд нь хариу хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ тайлан 2023 оны 11 сарын 22-нд Боловсрол шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн. | *100%* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус төвийн 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн **220** тушаал, **378** явсан бичиг, **151** ирсэн бичиг болон хамтран ажиллагч байгууллагуудтай байгуулсан **1095** гэрээ зэрэг баримт бичгүүдийг архивын тухай хууль, холбогдох бусад журам, стандартын дагуу үдэж хавтаслан **45** хадгаламжийн нэгж үүсгэсэн. | |

---oOo---